



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2017. он 05 дугаар
сарын 30.-ны өдөр

Дугаар
Xэг/909

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Н.УЧРАЛ ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Тамхины хяналтын тухай хуулийн 6.7.14 дэх заалтын хэрэгжилтийн талаар Танаас Монгол Улсын Ерөнхий сайдад хандан тавьсан асуулгын дагуу Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газраас холбогдох мэдээллийг гаргуулан авч Эрүүл мэндийн яамаар нэгтгүүлэн боловсруулж асуулгын хариуг Танд үүгээр хүргүүлж байна.

Хавсралт *Ж.* хуудас. Холбогдох байгууллагаас ирүүлсэн албан бичгийг хавсаргав.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Ж.МӨНХБАТ

ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН 6.7.14, 7.3 ДАХЬ ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлаар 2004 онд соёрхон баталж нэгдэн орсон “Тамхины хяналтын суурь конвенци”-ийн үндсэн зарчим, зорилтыг “Тамхины хяналтын тухай хууль”-д тусган УИХ-аар 2012 онд батлуулсан. Тус конвенцид 2017 оны байдлаар ДЭМБ-ын 180 улс орон нэгдэн орж, 168 ажиглагчтай болоод байна.

Тамхины хяналтын тухай хууль 2005 онд батлагдаж “ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор тамхи худалдахыг хориглох тухай” 6.7.14 дахь заалтыг 2012 оны хуулиар 10 дугаар сарын 24-ний өдрийн хуулиар нэмж, уг заалт 2013 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж улс орон даяар хэрэгжиж эхэлсэн.

Тус заалтыг хуульд тусгасан үндэслэл:

Монгол Улсад сургуулийн 5-17 насны хүүхдүүд хүн амын 20 гаруй хувийг эзэлдэг бөгөөд нийгэмд болж байгаа зүйлсийг сонирхон дуурайх, суралцах, амархан автах зэрэг бие бялдар, оюун санааны өсөлт, хөгжилтийн онцгой үедээ байгаа хүн амын томоохон бүлэг юм байна.

Тамхины худалдааг хүүхэд залуучуудад ойртуулан тамхины хэрэглээг нэмэгдүүлж, улмаар донтуулж хараат болгох замаар ашгаа зузаатгах тамхи үйлдвэрлэгчийн худалдааны бодлогоос сэргийлэх, бие бялдар, оюун санааны өсөлт, хөгжилтийн онцгой үедээ байгаа хүүхэд, өсвөр үеийнхнийг хорт хавдар, зүрх судасны өвчин, амьсгалын замын өвчлөл зэрэг 400 гаруй өвчний шалтгаан болсон тамхины хорт утаанд нэрвэгдэх хор хөнөөлөөс сэргийлэх, суралцагчдын эрүүл мэндэд ээлтэй, цэвэр цэмцгэр эрүүл орчинг сургуулийн орчимд бүрдүүлэх, хүүхэд, өсвөр үеийнхнийг тамхи худалдан авагч болж, донтохоос сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор дээр дурдсан заалтыг хуульд тусгасан.

Тамхины үйлдвэрлэл, худалдааны сүлжээ нь хүн амын зонхилох хувийг эзэлдэг хүүхэд, залуусыг тамхинд оруулах, шинэ залуу үеийнхнийг удаан хугацааны хэрэглэгч болгохоор тооцоолон хүүхэд, залуус руу чиглэсэн идэвхтэй үйл ажиллагаа явуулж, зах зээлээ өргөтгөн ашгаа нэмэгдүүлэх худалдааны олон талт стратеги хэрэгжүүлдэг. Тамхины үйлдвэрлэл нь өөрийн худалдааны сүлжээг өргөтгөхийн тулд боломжтой бүх аргыг хэрэглэн жил бүр хэдэн арван тэрбум амдолларыг зарцуулж байна.

Тамхи нь хүний ердийн хэрэглээ биш бөгөөд маш их хор хөнөөлтэй, 400 гаруй өвчний эх суурийг тавьдаг, амархан донтдог, хэрэглэгчээ төдийгүй тэдний гэр бүл, хамт олон, найз нөхдөө хордуулж, өвчлөх эрсдэлийг ихэсгэдэг бүтээгдэхүүн бөгөөд анх орсон нас залуу байх тусам тамхийг тогтмол татаж, түүнээс гарах магадлал багатай, хор хөнөөл нь бие махбодид илүү сөрөг нөлөөлөл үзүүлдгийг эрдэмтэд тогтоогоод байна. Тамхичин нь тамхинд агуулагдах никотинд донтох хараат байдалд орсоны улмаас тамхи авахын тулд байгаа мөнгөө хоол хүнс, бусад амьдралын зайлшгүй хэрэгцээт зүйлдээ зарцуулахын оронд тамхинд зарцуулдагаас гадна аажмаар тамхинаас болж үүссэн өвчин, эмгэгээ эмчлүүлэхэд бүр их зардал хэрэгтэй болдог байна.

Тамхины хяналтын тухай хууль хэрэгжсэнээр дараах үр дүн гарч байгаа нь судалгаагаар тогтоогдсон. Тухайлбал, Эрүүл мэндийн яамнаас ДЭМБ-тай хамтран сурагчдын дундах тамхины хэрэглээний тархалтыг 2003, 2007, 2010, 2013 онд

тогтооход тамхи хэрэглэдэг 13-15 насны сурагчид 2007 онд 23.4 хувь байсан бол 2014 оны байдлаар 14.3 хувь болж буурсан байна. Түүнчлэн 2007 онд тамхины утаанд 54.4 хувь гэртээ, 55.5 хувь нь олон нийтийн газар өртдөг байсан бол 2014 оны судалгаагаар 42.4 хувь гэртээ, 49.8 хувь нь олон нийтийн газар өртдөг болж, буурах хандлагатай болжээ.

2007 онд явуулсан “Дэлхийн залуучуудын тамхины хэрэглээний судалгаа”-гаар ЕБС-ийн 13-15 насны сурагчдын 81.1 хувь нь тамхийг худалдан авах боломж ихтэй, тэдний насыг үл харгалзан дэлгүүр, сургууль орчмын түргэн үйлчилгээний цэгээр тамхийг чөлөөтэй худалддаг, 60 хувь нь тамхины зар сурталчилгааг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл болон гудамжны самбараас хардаг гэсэн дүн гарчээ. Сурагчдын 79.1 хувь нь тамхийг олон нийтийн үйлчилгээний газар татахыг хориглосон хуулийн заалтыг мөрдүүлэх нь чухал гэж үзсэн байна.

ДЭМБ, НЭМХ-ийн “Сургуульд суурилсан хүүхдийн эрүүл мэндийн судалгаа”-аар 14 наснаас өмнө тамхи татаж үзсэн хүүхэд 2010 онд 78.6 хувь байсан бол 2013 оны тус судалгаагаар 61.5 хувь болж буурсан байна.

Монгол Улсын 15-64 насны хүн амыг хамруулан явуулсан “Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийн тархалтыг тогтоох судалгаа”-гаар 15-24 насныхны тамхи таталтын тархалт 2009 онд 16.4 хувь байсан бол 2013 онд 14.1 хувь болж буурсан байна. Судалгаагаар хоёр хүн тутмын нэг (42.9%) нь гэртээ, гурван хүний нэг нь (35.6%) ажлын байрандаа дам тамхидалтад өртөж байгааг тогтоожээ.

Тамхины хяналтын тухай хуулийн “Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор тамхи худалдах”-ыг хориглосон заалтын хэрэгжилттэй холбоотойгоор тус хуулийн 7.3 дахь хэсгийн дагуу сум, дүүргийн Засаг дарга нар тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн зохицуулалтыг хийж, тусгай зөвшөөрөл олгож байна.

УИХ-ын гишүүний асуулгатай холбоотойгоор аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар бүх сум, дүүргээс зохих асуумжийн дагуу мэдээлэл авч нэгтгэсэн байна. Мэдээллийн дагуу сум, дүүргийн Засаг дарга нар хуулийн 7.3 дахь заалтыг үндэслэн тайлант хугацаанд улсын хэмжээнд 5543 ААН-ийн нэгжийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 593-г түдгэлзүүлж, 223 зөвшөөрлийг дахин сэргээж, 3972 зөвшөөрлийг шинээр олгосон байгаа бөгөөд 2017 оны 5 сарын 15-ны байдлаар улсын хэмжээнд 4059 аж ахуйн нэгж сургуулиас 500 м-ээс гаднах талбайд тамхи худалдах үйл ажиллагаа эрхэлж байгаа юм байна. Нэгдсэн дунгээр нэг сургууль тойроод дунджаар 6.3 аж ахуйн нэгж тамхи худалдах үйл ажиллагаа эрхэлдэг байна /Хавсралт 1/.

Тамхины хяналтын тухай хуулийн 6.7.14 дэх заалттай холбоотойгоор хуулийн 11.1 дэх хэсгийн дагуу бүх шатны Засаг дарга, мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, цагдаа болон хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтан тус тусын эрх хэмжээний дагуу хяналт тавьж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хуулийн уг заалтын дагуу тайлант хугацаанд Цагдаагийн Ерөнхий газраас ерөнхий болон тусгай 401 удаагийн арга хэмжээг Засаг даргын ажлын алба, эрүүл мэндийн байгууллага, мэргэжлийн хяналтын алба, Татварын алба болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулж, давхардсан тоогоор 20453 иргэн, 12017 аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаж, зөрчлийг арилгуулахаар 2456 шаардлагыг хүргүүлж, биелэлтийг тооцож ажилласан байна. Түүнчлэн тус

хуулийг сурталчлах зорилгоор 1493 удаагийн сургалт, уулзалт, зөвлөгөөн зохион байгуулж, давхардсан тоогоор 183956 хүнийг хамруулж, 67976 ширхэг гарын авлага, тараах материалыг тарааж ажилласан байна /хавсралт 2/.

МХЕГ-аас хяналт, шалгалт, зөвлөн туслах үйлчилгээ хийхээр зарлагдсан 1176 их болон дунд эрсдэлтэй хүнсний сүлжээний газруудаас 795 аж ахуйн нэгжид, “Төрийн хяналт, шалгалтын тухай” хуулийн 5²¹ дэх заалтыг үндэслэн ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ирүүлсэн хүсэлт, гомдлын дагуу 238 аж ахуйн нэгж, 73 иргэдийн үйл ажиллагаанд “Тамхины хяналтын тухай” хуулийн хэрэгжилтийг шалгасан байна. 2016 оны тайлант хугацаанд нийт 254 зөрчил илрүүлэн, 1507 хайрцаг, 5 ширхэг янжуур тамхи, 1.9 кг тамхины бэлдэц, нийт 4229.0 мянган төгрөгийн үнэ бүхий тамхи, тамхин бүтээгдэхүүнийг хураах улсын /ахлах/ байцаагчийн акт тогтоон, Нийслэлийн Засаг даргын дэргэдэх “Захиргааны журмаар эд зүйл хураах, улсын орлого болгох, үнэлэх, устгах үйл ажиллагаанд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулах үүрэг бүхий нийслэлийн орон тооны бус зөвлөл”-д шилжүүлэн, зөрчил гаргасан аж ахуйн нэгжийн албан тушаалтан, иргэнд нийт 6927.0 мянган төгрөгийн шийтгэврийн арга хэмжээ тооцож, барагдуулжээ.

МХЕГ-ын шалгалтаар онцгой албан татварын тэмдэггүй, эрүүл мэндийн дүгнэлтгүй, эрүүл мэндийн хор нэлөөний талаар зурагт анхааруулгагүй, шошгын зөрчилтэй, Монгол Улсад худалдахыг зөвшөөрсөн тэмдэглэлгүй импортын тамхи, тамхин бүтээгдэхүүнийг худалдаалах, гар дээрээс болон тусгай зөвшөөрөлгүйгээр тамхи худалдаалах, дүнсэн тамхийг хувааж, янжуур тамхийг ширхэглэн зарах зэрэг зөрчил буурахгүй нэмэгдсэн байна. Тухайлбал, Япон Улсад үйлдвэрлэгдсэн “Caster” нэрийн янжуур тамхийг Гаалын татваргүй барааны дэлгүүрээс /Замын Үүд-Эрээний боомт/ худалдан авч хууль бусаар дотоодын хүнсний худалдааны сүлжээнд худалдаалж байсан байна.

Тамхины хяналтын тухай хуулийн 5.1.2-т “Төрийн бүх шатны болон нутгийн өөрөө удирдах байгууллага нь бүрэн эрхийнхээ дагуу хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах бодлогын хүрээнд дангаар буюу холбогдох бусад байгуулагатай хамтран ажиллах” гэсэн заалтын хэрэгжилт Нийслэлийн дүүргийн ЗДТГ-т хангалтгүй, хүн амын эрүүл мэндийг дэмжих, тамхины хор хөнөөлөөс хамгаалах бодлогын хүрээнд гаргасан эрх зүйн акт учир дутагдалтай, зөвхөн тусгай зөвшөөрөл олгох хүрээнд ажиллаж байгаад анхаарах шаардлагатай байгаа юм байна.

Мэргэжлийн хяналтын байгууллагаас 2016 онд хийсэн тандалт, судалгаа /дүнг хавсаргав/-ны явцад давхардсан тоогоор нийт 116 зөрчил илэрсэн ба нийтлэг илэрсэн зөрчил нь ерөнхий боловсролын сургуулиас 500 метр дотор болон тусгай зөвшөөрөлгүйгээр тамхин бүтээгдэхүүн худалдаалсан нь “Тамхины хяналтын тухай” хуулийн 6.7.12, 6.7.14 дэх заалтуудыг, Чингэлтэй дүүрэгт олгогдсон тусгай зөвшөөрөл дээр “Тамхины хяналтын тухай” хуулийн 6.7.7 дахь заалт “21 нас хүрээгүй хүнд тамхи худалдах, түүгээр тамхи худалдуулах” гэсэн заалтыг зөрчиж, 18 нас хүрээгүй хүнд тамхи худалдана гэж бичсэн, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум гар дээрээс худалдаа хийдэг иргэнд тусгай зөвшөөрөл олгосон нь “Тамхины хяналтын тухай” хуулийн 6.7.7 дахь заалтыг, тандалт судалгаанд хамрагдсан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн 70-75 хувь нь байгууллагын хөдөлмөрийн дотоод журамдаа тамхины хяналтын үйл ажиллагаатай холбогдсон зохицуулалтыг тусгаагүй байгаа нь “Тамхины хяналтын тухай” хуулийн 9.2 дахь заалтыг тус тус зөрчсөн зөрчлүүд нийтлэг байгаа юм байна. /Хавсралт 3/.

УИХ-ын гишүүний асуулгад бэлтгэх зорилгоор тус хуулийн заалтын үр өгөөжийг хүртэгч боловсролын байгууллага, сурагчдын санал бодлын талаарх мэдээлэл ирүүлэхийг БСШУСЯ-наас ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2017 он 5 дугаар сарын 12-ны 16/1823 дугаар албан бичгээр хүссэний дагуу БСШУСЯ яам мэдээлэл бэлтгэн ирүүлсэн юм байна. /Хавсралт 4/.

Тамхины хяналтын тухай хуулийн дээрх заалт хэрэгжсэнээр сургуулийн орчинд болон сурагчдад маш олон эерэг өөрчлөлтүүд гарсан байна. Тухайлбал:

- тамхи татдаг байсан хүүхдүүдийн тамхины хэрэглээ багассан бөгөөд өсвөр насны хүүхдүүдийн хичээл таслах, тамхинд донтсон нэгнийгээ уруу татан тамхинд оруулах зэрэг сөрөг үзэгдлүүд эрс багассан;
- сургуулийн орчинд тамхи татдаг асуудал байхгүй болсноор сурагчид, багш нар дам тамхидалтад өртөхгүй болсон;
- тамхи татахыг сонирхдог хүүхдүүд шууд худалдан авах боломжгүй болсон;
- сургуулийн орчинд тамхи татахгүй байснаар хичээл таслалт, завсарлагаанаар хожимдох байдал үгүй болсон;
- сургуульд ажиллагсад суралцагчдын нүдэн дээр шууд тамхи татах байдал арилсан, өдөрт олон удаа татдаг байдал багасаж цөөрсөн;
- сургуулийн орчинд эцэг эхчүүд тамхи татах явдал багассан;
- сумын хэмжээнд сургуулийн ойролцоо худалдаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжтэй сургуулийн хүүхдүүдэд тамхи худалдаалахгүй байх талаар гэрээ байгуулж ажилласан;
- зарим үйлчилгээний газраас тамхины эвгүй үнэр үнэртэхээ больсон;
- тамхи худалдаалдаг дэлгүүр нь холдсоноос тамхиндаа хүрч чадахаа больсон, зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт хориглох тэмдгүүд байрласан, иргэд хамт олон наиз нөхөд үр хүүхэд шаардлага тавьдаг болсноор эцэг эхчүүд, ажилчид тамхинаас гарах нь ихсэж, тамхи татах нь цөөрсөн.

Сөрөг байдал:

- сүүлийн үед хүүхдүүдэд тамхи зардаг \ширхэгээр худалдаалдаг дэлгүүрүүд\ байдал мэр сэргээхийн болсон. Сургуулийн зүгээс шууд арга хэмжээ авах хуулийн үндэслэл байхгүй. Цагдаагийн байгууллагад хандаад шалгалт хийхээр илэрдэггүй \нуудаг\ байдал илрэх болсон юм байна.

**Сургуульд суурилсан хүүхдийн эрүүл мэндийн судалгаа,
ДЭМБ, НЭМХ, 2010, 2013 он**

№	Он	Нас	Бүгд, %	Эр, %	Эм, %	Хэн нэг нь дэргэд нь тамхи татдаг гэж хариулсан (%)	14 наснаас өмнө тамхи татаж үзсэн (%)	Анх татаж эхэлсэн нас, тоо
1.	2010	13-15 нас	5.4	9.2	2.0	63.8	78.6	
2.	2013	13-15 нас	5.9	8.3	3.5	59.6	82.0	
		15-17 нас	17.9	26.9	9.7	64.2	41.1	

**Дэлхийн залуучуудын тамхины хэрэглээний тархалтын судалгаа,
ДЭМБ, НЭМХ, 2007, 2014 он**

Он	Нас	Тамхины хэрэглээ, %		Тамхины утаанд өртөлт, %		Тамхийг хаях хүсэлтэй, %	Дэлгүүр, ТҮЦ худалдан авсан, %	Үнэгүй тамхи санал болгосон
		Ямар нэгэн тамхи	Янжуур тамхи	Гэрт	Олон нийтийн газар			
2003	13-15 нас	38.8	-	58.2	-	-	-	-
2007	13-15 нас	23.4	6.9	54.4	55.5	88.6	79.0	10 хүүхдийн 1-д
2014	13-15 нас	14.3	5.6	42.4	49.8	8/10	704	-

**ХБӨ-ий эрсдэлт хүчин зүйлийн тархалтын судалгаа, 15-64 нас
ДЭМБ, НЭМХ 2009, 2013 он**

Он	Нас	Тамхи таталтын тархалт, %			Тогтмол тамхи татдаг, %	Тамхи татаж эхэлсэн дундаж нас	15-24 насныхны тамхи таталт, %
		НИЙТ	Эрэгтэй	Эмэгтэй			
2005	15-64 нас	27.6	43.1	4.1	24.2	19.8	8.9
2009	15-64 нас	27.5	48.0	6.9	24.3	19.2	16.4
2013	15-64 нас	27.1			24.8	19.7	14.1



**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41, 32-09-16
И-мэйл: moh@moh.gov.mn, http://www.mohs.mn

2017.05.29 № 19/2102
таний _____-ны № _____-т

Г МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГААЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Ж.МӨНХБАТ ТАНАА


Г Асуулгын хариу хүргүүлэх тухай Г

Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал Монгол Улсын Ерөнхий сайдад хандан “Тамхины хяналтын тухай хууль”-ийн 6.7.14 дэх заалтын хэрэгжилтийн талаар асуулга тавьсаныг таны энэ оны 5 дугаар сарын 05-ны өдрийн ХЭГ/759 тоотоор тус яаманд ирүүлсэн. Тус асуулгыг аймаг, нийслэлийн Засаг дарга, Цагдаагийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, түүнчлэн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, тэдгээрийн харьяалах байгууллагуудаас мэдээлэл авч танилцуулгыг нэгтгэн хүргүүлж байна.

Хавсралт. Дээрх байгууллагуудаас ирүүлсэн мэдээллийг хавсаргав.

Хүндэтгэсэн,

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

084309

Хүснэгт 2.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

14201 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо,
Самбуугийн гудамж 18, Утас: 7011-5507, Факс: 7011-5507,
Web: www.police.gov.mn, E-mail: info@police.gov.mn

2017.05.18 № 01/323
таний _____ -ны № _____ -т

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ГИШҮҮН, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД
А.ЦОГЦЭЦЭГ ТАНАА

Г Мэдээлэл хүргүүлэх тухай Г

Улсын Их Хурлын гишүүн Н.Учралаас Монгол Улсын Ерөнхий сайдад хандан Тамхины хяналтын тухай хуулийн 6.7.14 дэх заалтын хэрэгжилтийн талаар тавьсан асуултын хүрээнд холбогдох мэдээллийг хүргүүлж байна.

Тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, сурталчлах зорилгоор 2015 оны 07 дугаар сараас хойш нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас ерөнхий болон тусгай 401 удаагийн арга хэмжээг Засаг даргын ажлын алба, Эрүүл мэндийн байгууллага, Мэргэжлийн хяналтын алба, Татварын алба болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулж, давхардсан тоогоор 20453 иргэн, 12017 аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаж, зөрчлийг арилгуулахаар 2456 шаардлагыг хүргүүлж, биелэлтийг тооцож ажиллажээ.

Мөн уг хуулийг сурталчлах зорилгоор 1493 удаагийн сургалт, уулзалт, зөвлөгөөн зохион байгуулж, давхардсан тоогоор 183956 хүнийг хамруулж, 67976 ширхэг гарын авлага, тараах материалыг тарааж ажилласан байна.


Зарим сумын төвийн нутаг дэвсгэр бүхэлдээ Ерөнхий боловсролын сургуулийн 500 метр радиуст багтаж тамхи худалдаалах зөвшөөрөл олгогддоггүй нь бодит амьдралд нийцэхгүй, тамхины худалдаа нууц далд байдалд орох нөхцөлийг бүрдүүлж, иргэд цагдаагийн ажилтны хооронд үл ойлголцол үүсэх зэрэг сөрөг үр дагаврыг бий болгож байна.

Цаашид цагдаагийн байгууллагаас хуулийн хэрэгжилтийг хангаж хамтран ажиллах болно.

Жич: Бүртгэгдсэн зөрчил, шийдвэрлэлтийн мэдээллийг хавсаргав.

Хавсралт 3 хуудастай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



Ө.ЭНХТӨР

0902998

ТАМХИНЫ ХЯНДЛТЫН ТУХАЙ ХҮҮЛИЙН ЗӨРЧИЛ, ТОРГУЛЬ

Хавсралт 1

№	аймаг	2015 оны 07 дугаар сарын											
		TXTX-nih 6 AYRAPP											
1	Архангай	1	50000	1	50000	0	0	0	0	0	0	0	0
2	Баян-Өлгий	2	100000	2	100000	0	0	0	0	0	0	0	0
3	Баянхонгор	3	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
4	Булган	4	50000	1	50000	0	0	0	0	0	0	0	0
5	Говь-Алтай	5	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
6	Говьсумбэр	6	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
7	Дархан-Ул	7	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
8	Дорноговь	8	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
9	Дорнод	9	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
10	Дундговь	10	130000	3	130000	0	0	0	0	0	0	0	0
11	Завхан	11	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
12	Орхон	12	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
13	Өвөрхангай	13	1	50000	1	50000	0	0	0	0	0	0	0
14	Өмнөговь	14	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
15	Сүхбаатар	15	2	100000	2	100000	0	0	0	0	0	0	0
16	Сэлэнгэ	16	6	300000	0	0	0	0	0	0	0	0	0
17	Төв	17	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
18	Үзүүл	18	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
19	Ховд	19	950000	0	0	0	0	0	0	0	0	0	0
20	Хөвсгөл	20	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
21	Хэнтий	21	1	50000	0	0	0	0	0	0	0	0	0
Орон нутаг												0	0
22	Улаанбаатар	22	30	1500000	9	430000	0	0	0	0	0	0	0
23	Баянзүрх	23	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
24	Баянгол	24	56	280000	0	0	0	0	0	0	0	0	0
25	Сүрбаатар	25	21	105000	0	0	0	0	0	0	0	0	0
26	Чингелтэй	26	4	200000	0	0	0	0	0	0	0	0	0
27	Хан-Ул	27	1	50000	0	0	0	0	0	0	0	0	0
28	Сонгинохайрхан	28	5	30000	0	0	0	0	0	0	0	0	0
29	Нийтийн	29	2	100000	1	50000	0	0	0	0	0	0	0
30	Нийтийн	30	1	50000	0	0	0	0	0	0	0	0	0
31	Баянхангай	31	2	10000	0	0	0	0	0	0	0	0	0
32	Нийслэл	32	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
33	Нийт	33	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Нийт												0	0
Нийт												0	0
Нийт												0	0
Нийт												0	0
Нийт												0	0
Нийт												0	0
Нийт												0	0
Нийт												0	0
Нийт												0	0
Нийт												0	0
Нийт												0	0
Нийт												0	0
Нийт												0	0
Нийт												0	0
Нийт												0	0
Нийт												0	0
Нийт												0	0
Нийт												0	0
Нийт												0	0
Нийт												0	0
Нийт												0	0
Нийт												0	0
Нийт												0	0
Нийт												0	0
Нийт												0	0
Нийт												0	0
Нийт												0	0
Нийт												0	0
Нийт												0	0
Нийт												0	0
Нийт												0	0
Нийт												0	0
Нийт												0	0
Нийт												0	0
Нийт													

ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗЕРЧИЛ, ТОРГУУЛЬ

Хавсралт 2

ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХҮХҮҮЛИЙН ЗӨРЧИЛ, ТОРГУЛЬ

Хавсралт 3

№	аймаг	Нийт									
		TXTX-nih 6 AYrAap			TXTX-nih 6 AYrAap			TXTX-nih 6 AYrAap			TXTX-nih 6 AYrAap
3yinnih 6.7.8 Aaxb xacar		3yinnih 6.7.9 AYrAap		3yinnih 6.7.10 Aaxb xacar		3yinnih 6.7.11 Aaxb xacar		3yinnih 6.7.12 Aaxb xacar		3yinnih 6.7.13 Aaxb xacar	
3ypryurb	3ephrin	3ypryurb	3ephrin	3ypryurb	3ephrin	3ypryurb	3ephrin	3ypryurb	3ephrin	3ypryurb	3ephrin
1 Адхантай											
2 Баян-Өлгий		0									
3 Баянхонгор		4	200000		36	1800000		0	0	1	50000
4 Булган		0			7	350000		1	50000	40	2000000
5 Говь-Алтай		0			1	50000		0	0	9	450000
6 Говьсүмбэр		0			2	1000000		0	0	1	500000
7 Дархан-Уул		1	50000		1	50000		0	0	2	1000000
8 Дорноговь		2	100000		5	250000		0	0	1	500000
9 Дорнод		1	50000		17	850000		2	100000	8	4000000
10 Дундговь		6	300000		0	0		0	0	19	950000
11 Завхан		0			0	0		0	0	7	350000
12 Орхон		0			4	200000		0	0	0	0
13 Фөврхангай		0			9	450000		0	0	4	2000000
14 Эмнэговь		0			6	300000		0	0	9	450000
15 Сүхбаатар		0			13	650000		0	0	6	3000000
16 Салэнгэ		0			5	250000		0	0	13	6500000
17 Төв		0			5	250000		0	0	5	2500000
18 Увс		0			3	150000		1	50000	6	3000000
19 Ховд		0			1	50000		0	0	4	2000000
20 Хөвсгөл		4	200000		9	450000		5	250000	4	2000000
21 Хэнтий		0			3	150000		2	100000	13	6500000
Орон нутаг	0 0 0 0 0 0 0 0 0 0 0 0	12	600000	0 0 0 0 0 0 0 0 0 0 0 0	13	3190000	0 0 0 0 0 0 0 0 0 0 0 0	2	100000	0	5
22 Улаанбаатар					13	9880000	0 0 0 0 0 0 0 0 0 0 0 0	8	400000	23	36900000
23 Баянзүрх		73	3650000		0	0	12	600000	0 0 0 0 0 0 0 0 0 0 0 0	27	1350000 0 0 0 0 0 0 0 0 0 0 0 0
24 Баянгол		9	450000		60	2970000		4	200000	2	1000000
25 Сүхбаатар	13	650000			179	8950000		4	200000	140	6970000
26 Чингэлтэй					70	3500000		4	200000	0	9600000
27 Хан-Уул					28	1400000		2	100000	3	1500000
28 Сонгинохайрхан		2	100000		31	1550000		5	250000	2	1000000
29 Нийгээл		1	50000		40	2085000		1	50000	32	1600000
30 Баганчур		0			1	50000		0	0	2	1000000
31 Баганхангай		0			6	300000		2	100000	43	2235000
Никслэл	0 0 0 0 0 0 0 0 0 0 0 0	98	4800000	0 0 0 0 0 0 0 0 0 0 0 0	417	20805000	0 0 0 0 0 0 0 0 0 0 0 0	11	550000	0	27555000
Нийт	0 0 0 0 0 0 0 0 0 0 0 0	110	5500000	0 0 0 0 0 0 0 0 0 0 0 0	664	30795000	0 0 0 0 0 0 0 0 0 0 0 0	41	2050000	0 0 0 0 0 0 0 0 0 0 0 0	39695000

Хавсралт 3.

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗРААС ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

Тайлант хугацаанд Мэргэжлийн хяналтын газраас хяналт, шалгалт, зөвлөн туслах үйлчилгээ хийхээр зарлагдсан 1176 их болон дунд эрсдэлтэй хүнсний сүлжээний газруудаас 795 аж ахуйн нэгжид, “Төрийн хяналт, шалгалтын тухай” хуулийн 5²¹ дэх заалтыг үндэслэн ахуйн нэгж, байгуулага, иргэдээс ирүүлсэн хүсэлт, гомдлын дагуу 238 аж ахуйн нэгж, 73 иргэдийн үйл ажиллагаанд “Тамхины хяналтын тухай” хуулийн хэрэгжилтийг шалгасан байна. Мөн жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийг Дэлхий нийтээр “Тамхитай тэмцэх өдөр” болгон зарласантай холбогдуулан Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийнхүрлын Тэргүүлэгчдийн 2002 оны “Санаачилгыг дэмжих тухай” 83 тоот тогтоолын хэрэгжилтэд хяналт шалгалт хийсэн байна.

“Тамхигүй өдөр”-ийн шалгалтаар дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтэс, Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн хэсгээс “Тамхигүй өдөр”-ийг угтан урьдчилан сануулсан мэдэгдэх хуудас, сурталчилгааны материал тараасан нь зөрчил гарахаас урьдчилан сэргийлсэн үр дүнтэй ажил болж хэвшсэн. 2016 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн шалгалтын явцад Сүхбаатар, Багахангай дүүрэгт хийсэн шалгалтаар тамхи худалдан борлуулж буй зөрчил илрээгүй, шалгалтанд хамрагдсан төрийн болон төсвийн байгууллага аж ахуйн нэгжүүд “Тамхины хяналтын тухай” хуулийн 9.3-д заасан тамхи татахыг хориглосон анхааруулах тэмдэгийг шаардлагатай газар нааж, Тамхины тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулсан байлаа.

2016 оны тайлант хугацаанд нийт 254 зөрчил илрүүлэн, 1507 хайрцаг, 5 ширхэг янжуур тамхи, 1.9 кг тамхины бэлдэц, нийт 4229.0 мянган төгрөгийн үнэ бүхий тамхи, тамхин бүтээгдэхүүнийг хураах улсын /ахлах/ байцаагчийн акт тогтоон, Нийслэлийн Засаг даргын дэргэдэх “Захиргааны журмаар эд зүйл хураах, улсын орлого болгох, үнэлэх, устгах үйл ажиллагаанд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулах үүрэг бүхий нийслэлийн орон тооны бус зөвлөл”-д шилжүүлэн, зөрчил гаргасан аж ахуйн нэгжийн албан тушаалтан, иргэнд нийт 6927.0 мянган төгрөгийн шийтгэврийн арга хэмжээ тооцож, барагдуулжээ. Шалгалтаар илэрсэн зөрчлийн тоог 2015 оны мөн үеийнхтэй харьцуулбал 1 дахин нэмэгдсэн байна.

Шалгалтаар онцгой албан татварын тэмдэггүй, эрүүл мэндийн дүгнэлтгүй, эрүүл мэндийн хор нөлөөний талаар зурагт анхааруулгагүй, шошгын зөрчилтэй,

Монгол Улсад худалдахыг зөвшөөрсөн тэмдэглэлгүй импортын тамхи, тамхин бүтээгдэхүүнийг худалдаалах, гар дээрээс болон тусгай зөвшөөрөлгүйгээр тамхи худалдаалах, дүнсэн тамхийг хувааж, янжуур тамхийг ширхэглэн зarah зөрчил буурахгүй нэмэгдсэн байна. Тухайлбал Япон Улсад үйлдвэрлэгдсэн “Caster” нэрийн янжуур тамхийг Гаалын татваргүй барааны дэлгүүрээс /Замын Үүд-Эрээний боомт/ худалдан авч хууль бусаар дотоодын хүнсний худалдааны сүлжээнд худалдаалж байна.

“Монгол тамхи Со” ХХК, “Дольфин” ХХК-ийн нийт 29 нэрийн тамхи, тамхин бүтээгдэхүүнийг хүнсний аюулгүй байдлын лавлагаа лабораторийн хими, физик, хор судлал, цацрагийн шинжилгээнд хамруулан Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтыг үндэслэн улсын ахлах байцаагчийн стандартын шаардлага хангасан тухай дүгнэлт 6 үйлдсэн байна. “Монгол тамхи Со” ХХК нь 2016 онд тамхин бүтээгдэхүүний үйлдвэрийн үйл ажиллагаандaa НАССР тогтолцоо нэвтрүүлж олон улсын гэрчилгээ авсан байна. Үйл ажиллагаа явуулж байгаа Монгол тамхи Со, Долфин ХХК-иуд эрсдэлийн үнэлгээгээр бага үнэлэгдсэн тул 2016 онд төлөвлөгөөт шалгалтанд хамрагдаагүй болно.

Дүүрэг дэх засаг даргын тамгын газруудад Тамхины хяналтын тухай хуулийн 5 дугаар 5.1.2 дах “Төрийн бүх шатны болон нутгийн өөрөө удирдах байгууллага нь бүрэн эрхийнхээ дагуу хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах бодлогын хүрээнд дангаар буюу холбогдох бусад байгуулагатай хамтран ажиллах” заалтын хэрэгжилт хангалтгүй, хүн амын эрүүл мэндийг дэмжих, тамхины хор хөнөөлөөс хамгаалах бодлогын хүрээнд гаргасан эрх зүйн акт учир дутагдалтай, зөвхөн тусгай зөвшөөрөл олгох хүрээнд ажиллаж байгаад анхаарах шаардлагатай байна.

Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын тамгын газрын худалдаа, үйлчилгээний хэлтэстэй хамтран “Утаат тамхигүй Улаанбаатар” хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх, эрчимжүүлэх” сургалтыг зохион байгуулж, 1-19 дүгээр хорооны Засаг дарга, Эрүүл мэндийн төв, Боловсролын хэлтсийн нийт 54 албан тушаалтан мэргэжилтэн хамрагдav.

“Тамхины хяналтын тухай” хууль болон “Тамхи татахаа болиход гарах өөрчлөлтүүд”, “Тамхины хор хөнөөл”, “Тамхины утааны бүтэц” зэрэг сэдэвт 4 нэр төрлийн зөвлөмжийг 80 ширхэгийг тараасан. Дэлхийн нийтийн тамхигүй өдрийг тохиолдуулан MYOHP-1 удаа, MYONT 1, Ийгл TV 1 удаа хуулийн хэрэгжилтийн төвшин, илэрч буй зөрчлийн шалтгаан нөхцөл, анхаарах асуудлын талаар ярилцлага мэдээлэл өгсөн.

Шалгалтаар илэрч буй зөрчилтэй холбогдуулан Тамхины хууль бус импорт, худалдааг таслан зогсооход хамтран ажиллах талаар Гааль, Татварын ерөнхий газар, Нийслэлийн Захирагчийн ажлын албанда санал хүргүүлж ажиллаж байна.

Завхан аймгийн МХГ-аас ЕБС-ийн ахлах ангийн 48 хүүхдүүдээс түүвэр аргаар тамхины хэрэглээний талаар асуумж судалгаа авч дүгнэлт өгч ажилласан байна. Судалгаагаар судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 54,1% нь тамхийг хэрэглэж үзсэн хэрэглэдэг, тамхия хаанаас авдаг вэ? Гэсэн асуумжинд 37,5% нь тамхи зардаг дэлгүүрээс, 8.3% нь гэрээсээ, 43,7 хувь нь найз нөхдөөсөө авдаг гэсэн хариултыг өгсөн байна. Эндээс харахад зөвшөөрөлгүй цэгт тамхи худалдаалдаг, 21 нас хүрээгүй хүүхдэд тамхи худалдахгүй байх заалт хэрэгжихгүй байгаа нь харагдаж байна.

ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ТАНДАЛТ СУДАЛГААГААР:

1. МХБ-аас 2016 онд хийсэн тандалт, судалгааны явцад давхардсан тоогоор нийт 116 зөрчил илэрсэн ба нийтлэг илэрсэн зөрчил нь ерөнхий боловсролын сургуулиас 500 метр дотор болон тусгай зөвшөөрөлгүйгээр тамхин бүтээгдэхүүн худалдаалсан нь “Тамхины хяналтын тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.12, 6.7.14 дэх заалтуудыг;

2. Чингэлтэй дүүрэгт олгогдсон тусгай зөвшөөрөл дээр “Тамхины хяналтын тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.7 дахь заалт “21 нас хүрээгүй хүнд тамхи худалдах, түүгээр тамхи худалдуулах” гэсэн заалтыг зөрчиж, 18 нас хүрээгүй хүнд тамхи худалдах, түүгээр тамхи худалдуулах/ гэж бичигдсэн, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум гар дээрээс худалдаа хийдэг иргэнд тусгай зөвшөөрөл олгосон нь “Тамхины хяналтын тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.7 дахь заалтыг;

3.. Тандалт судалгаанд хамрагдсан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн 70-75 хувь нь байгууллагын хөдөлмөрийн дотоод журамдаа тамхины хяналтын үйл ажиллагаатай холбогдсон зохицуулалтыг тусгаагүй байгаа нь “Тамхины хяналтын тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь заалтыг тус тус зөрчсөн зөрчлүүд нийтлэг байна.

МХЕГ-ИЙН ТАНДАЛТ СУДАЛГААНЫ ДҮН

№	Асуудлууд	Хэрэгжилтийн хувь	Тайлбар
1	Худалдаалж буй тамхины шошгонд зурагт анхааруулга нь хайрцагны нүүр ар талын 50-аас багагүй хувийг эзэлсэн	85,7%	
2	Тамхи нь эрүүл мэндийн хор хөнөөлийн тухай анхааруулгатай эсэх том тод харагдахуйц бичиг, зураг, дүрсээр харуулсан эсэх	96,3%	
3	Анхааруулга болон шаардлагатай тэмдэглэл нь монгол хэл дээр бичигдсэн эсэх	90%	
4	Тамхины найрлагад агуулагдах бохь никотин, бусад хорт бодисын хэмжээ болон дуусгавар болох хугацааг заасан эсэх	90,5%	
5	Тамхины хайрцаг сав баглаа боодол дээр илүү хор хөнөөл багатай гэсэн утгатай үг бичсэн, дүрслэл зураг байгаа эсэх	100%	
6	Зөвшөөрсөн цэгээс өөр газар тамхи худалдаж байгаа эсэх	50%	Ил задгай худалдаагаар, зөвшөөрөлгүй цэгт, хууль бус худалдаа эрхлэх тамхи тамхин бүтээгдэхүүн худалдах зөрчил нийтлэг илэрч байна.
7	Тамхийг ширхэглэн худалдах дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхины үйлдвэрлэсэн боодлыг задалж буюу ороож худалдах	98%	
8	Тамхи зарах автомат машин ажиллуулах	100%	
9	Тамхины борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор аливаа урамшуулалт худалдаа зохион байгуулах, сугалаа гаргах	100%	
10	Хайрцаг сав баглаа боодол дээр онцгой албан татварын тэмдэг, үйлдвэрлэсэн улс, үйлдвэрлэсэн он сар, үйлдвэр, импортлогчийн нэр, Монгол улсад худалдахыг зөвшөөрсөн тухий тэмдэглэлгүй	100%	
11	Интернэтээр тамхи худалдах	100%	Тандалтын явцад судалгаа хийхэд интернэтээр тамхи тамхин бүтээгдэхүүн худалдах зөрчил илрээгүй
12	ЕБС, дотуур байрнаас 500 метрийн дотор тамхи худалдах	50%	Энэ зөрчил нийтлэгээр илэрч байна.
13	Тусгай зөвшөөрөл	95%	Насны заалтыг буруу бичсэн, иргэнд зөвшөөрөл олгож байгаа

МХЕГ

ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ БСШУСЯ- НААС ИРҮҮЛСЭН МЭДЭЭЛЭЛ

Тамхины хяналтын тухай хуулийн 6.7.14 “ЕБС-ын хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор тамхи худалдах”-ыг хориглосон тухай заалтын хэрэгжилтийг аймгаар нэгтгэхэд Тамхины хяналтын тухай хууль хэрэгжсэнээр сургуулийн орчинд олон төрлийн эерэг өөрчлөлт гарчээ. Үүнд:

- тамхи татдаг байсан хүүхдүүдийн тамхины хэрэглээ багассан бөгөөд өсвөр насын хүүхдүүдийн тамхинд донтолт, нэгнийгээ уруун татан тамхинд оруулах зэрэг сөрөг үзэгдлүүд эрс багассан,
- сургуулийн орчинд тамхи татдаг асуудал байхгүй болсноор сурагчид багш нар дам тамхидалтад өртөхгүй болсон.
- тус хуулийн хэрэгжилтэд сургуулийн байгууллага, сургачдын өөрсдийн оролцоо нэмэгдэж, засаг дарга, мэргэжлийн хяналт, цагдаагийн байгууллагтай хамтран ажиллах ажиллагаа сайжирсан.
- тамхи татахыг сонирхдог хүүхдүүд шууд худалдан авах боломжгүй болсон,
- сургуулийн орчинд тамхи татахгүй байснаар хичээл таслалт, завсарлагаанаар хожимдох байдал үгүй болсон,
- сургуульд ажиллагсад суралцагчдын нүдэн дээр шууд тамхи татах байдал арилсан, өдөрт олон удаа татдаг байдал багасаж цөөрсөн,
- сургуулийн орчинд эцэг эхчүүд тамхи татах явдал багассан,
- сумын хэмжээнд сургуулийн ойролцоо худалдаа эрхэлж буй аж ахуйн нэгжтэй сургуулийн хүүхдүүдэд тамхи худалдаалахгүй байх талаар гэрээ байгуулж ажилласан,
- зарим үйлчилгээний газраас тамхины эвгүй үнэр үнэртэхээ больсон,
- тамхи худалдаалдаг дэлгүүр нь холдсон тамхиндаа хүрч чадахаа больсон, зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт хориглох тэмдгүүд байрласан, иргэд хамт олон найз нөхөд үр хүүхэд шаардлага тавьдаг болсноор эцэг эх, ажилчид тамхинаас гарах, тамхи татах нь цөөрсөн,
- Боловсролын салбарын сургуулийг ногоон орчин, эко орчин болгох бодлоготой уялддаг
- сүүлийн үед хүүхдүүдэд тамхи зардаг \ ширхэгээр худалдаалдаг дэлгүүрүүд байдал мэр сэр харагдах болсон. Сургуулийн зүгээс шууд арга хэмжээ авах хуулийн үндэслэл байхгүй. Цагдаагийн байгууллагад хандаад шалгалт хийхээр илэрдэггүй \ нуудаг\ байдал илэрч байгааг анхааралдаа авах шаардлагатай байна.

Санал:

- Хуулийг сайтар хэрэгжүүлэх, анх дагаж мөрдөж байсан шиг үйл ажиллагааг тогмолжуулах
- Сургуулийн орчинд тамхи **нууцаар** худалдаалж буй аж ахуйн үйл ажиллагааг зогсоох

**Тамхинны хяналтын тухай хуулийн 6.7.14 дэх заалтын хэрэгжилтийн талаар аймаг, нийслэлийн боловсролын
Байгууллагаас ирүүлсэн мэдээллийг нэгтгэл**

№	Аймгийн нэр	Хэрэгжилтийн байдал
1	Говьсүмбэр	<p>Ахлах дунд ангийн сурагчдаас тогтолц 2016 оны байдлаар 5 хүүхэд тутмын 1 нь тамхи татдаг байсан бол 2017 оны эхний утирлын байдлаар 9 хүүхэд тутмын 1 нь болж буурсан байна. Иймд цаашид тамхи хор уршиг, хорт зуршлын талаар тогтолц сургалт семнар зохион байгуулж сурагчдад мэдээлэл өгсөнөөр энэ тоо улам буурах хандлагатай байна.</p> <p>Сургуулиудын "School police" эцэг, эхтэй хамтран сургуулийн ойролцоо тамхи зарж буй 1 дэлгүүрийг илрүүлэн зохих арга хэмжээг авсан байна. Ингэснээр тамхи татах сургачдын тоо эрс буурч байна.</p> <p>Тамхинны хяналтын тухай хуулийн хэрэгжилтийн чиглэлээр 16 сургууль, 15 цэцэрлэгээс мэдээлэлтэй явууллаа. Сургууль, цэцэрлэгтийн ойролцоо 500 метрт тамхи худалдаалж байгаа аж ахуйн нэгж, дэлгүүр байхгүй байна.</p>
2	Дархан-Уул	-
3	Архангай	<p>Хуулийн заалт хэрэгжсэнээр ЕБС-ын ахлах ангийн хуудсанд татах, тамхинд уруу татагдаг нөхцөл байдал арилсан. Мөн сургуулийн орчинд эцэг эхчүүд, багш ажилчид тамхи татдаг нөхцөл байдал арилсан нь сургуулийн эзүүл, цэвэр орчин бий болох нөхцөл байдалд эерэгээр нөлөөлснөөс гадна, хуудсанд бусдаас буруу улгэр дууриалал авахаас урьдчилсан сэргийлж чадсан. Хуулийн заалтыг хэрэгжүүлж ЕБС-ын хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор тамхи худалдаах цэг байхгүй байгаа болно.</p> <p>ЕБС-ийн хичээлийн болон дотуур байрны ойролцоо буюу 500 м дотогш байрласан дэлгүүр, баар цэнгээний газруудад тамхи зарахгүй байхыг мэдэгдсэн албан бичгийг тухайн байгууллага, МХГазарт хургуулсэнээр ойролцоо байршилтай дэлгүүрт тамхи зарахгүй болсон нь багш, сурагчдын хичээл таслалтанд эерэгээр нөлөөлсөн.</p>
4	Баян-Өлгий	-
5	Ховд	<p>2016-2017 оны хичээлийн жилд Архи тамхигүй сургуулийн орчин хэлэлцүүлгийн үеэр сургууль орчмын дэлгүүрүүдэд мэргэжлийн хяналтын газартай хамтран хяналт хийж зэрчилтэй байсан 4 дэлгүүрийг илрүүлэн холбогдох газарт нь албан бичиг хургуулэн хуулийн дагуу арга хэмжээ авч ажилласан. Одоогийн байдлаар сургуулийн ойр орчимд тамхи худалдаалдаг цэг байхгүй.</p> <p>Аймгийн төвийн сургуулийн хувьд ойролцоо дэлгүүрүүдэд хяналт тавьж ажиллах боломжтой байдаг бол хөдөө орон нутаг сумдын хувьд гудамжны нэг талд дэлгүүр нөгөө талд сургууль цэцэрлэг байрладаг /зэрэгцэн нэг гудамж үүсгэсэн/ нь газарзүйн байршилын хувьд тодорхойгүй тул</p>

		хуулийн 6.7.14 дахь заалт зөрчигдөх явдал байсаар байна.
6	Булган	Цагдаагийн газар нь хэсгийн байцаагч нартай хамтарч давхардсан тоогоор тусгай зөвшөөрөлтэй тамхи худалддаг 56 цэгт Узлэг шалгалт зохион байгуулан хяналт тавьж ажилласан. Мөн энэ үеэр Тамхини хяналтын хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар 26 худалдагчид хууль эрхийн зөвлөгөө өгсөн
7	Өмнөговь	Энэхүү хуулийн заалттай холбоотойгоор Өмнөговь аймгийн ЕБ-ын 21 сургууль, төвийн 6 сургууль, 2 дотуур байраас 500 метр доторх нийт 25 аж ахуйн нэгж, орон нутгийн сумын ЕБ-ын 15 сургууль, ширхээр, гудамж талбайд, гар дээрээс худалдах, борлуулах хорилосонтой холбоотойгоор тамхини хэрэглээ, дам тамхидалтаас үүдэлтэй сөрөг үр дагавраас хүүхдийг хамгаалах эрэг өөрчлөлт гарч байна. Одоогийн байдлаар сургуулийн орчинд тамхи худалдаалж байгаа мэдээлэлгүй байна.
8	УВС	Увс аймгийн хэмжээнд ЕБ-ын 30 сургууль, 30 дотуур байр уйл ажиллагаа явуулж байна. Тамхини хяналтын тухай хууль хэрэгжснээр увс аймагт үйл ажиллагаа явуулж буй дэлгүүр, худалдааны цэгтүүдийн байршилд үнэлгээ хийж сургууль, дотуур байр 500 м дотор байралдаг дэлгүүрийг тамхи худалдаалахыг хориглосон. Тамхи худалдаалах тусгай зөвшөөрлийг тухайн сумын засаг дарга нар газарзүйн байршилыг харж олдог. Хууль хэрэгжснээр гарсан эрэг өөрчлөлт <ol style="list-style-type: none"> Сумын хэмжээнд тамхи худалдаалах цэгүүд цөөрсөн. Сургуулийн багш, сурагчид тамхи ширхэгээр худалдан авах, завсарлагааны үеэр тамхи татах зэрэг зөрчил, дутагдал эрс багассан байна. Сургуулийн <u>орчны бохирдол</u> багассан. Дам тамхидалт багассан. Хууль анхлан хэрэгжих үед сургуулийн орчинд тамхи татаж буй иргэнийг тортож арга хэмжээ авч байсан боловч сүүлийн үед хуулийн хэрэгжилт, түүнд тавих хяналт сурлах хандлагатай байна.
9	Дорнод	Хууль гарсан даруйд хэрэгжилт маш сайн байсан. -Сүүлийн үед сургуулийн ойр орчмын дэлгүүрүүд нууц байдлаар тамхи борлуулж байгаа нь судалгаагаар тогтоогдсон байгаа тухай орон нутгийн ТВ-ээр мэдээлж байгаа хэдий ч цагдаагийн шалгалтын дараа борлуулалт хийдэг. Үүнийг Цагдаа, МХГ хуулийн дагуу тортогарга хэмжээг авах хэрэгтэй байна.

10	Орхон	<ul style="list-style-type: none"> Тамхини хяналтын тухай хуулийн 6.7.14 хэсэг дэхь ЕБС-ийн хичэээлийн болон дотуур байрнаас 500 метрийн дотор тамхи худалдах"-ыг хориглосон заалтын дагуу сургуулийн орчимд ширхэгийн, хайрцааар тамхи зарахгүй байна. <u>Хуулийн дагуу сургуулийн нийгмийн ажилтан, эцэг эхийн зөвлөлтэй, багийн цагдаагийн газартай хамтран улиралд нэг удаа сургуулийн орчимд шалгалт хийдэг.</u> <u>Зөрчил илэрвэл мэргэжлийн хяналтын алба, сургуулийн захиргаатай хамтран таслан зогсох арга хэмжээг тоотмол авдаг. 5 дэлгүүрт арга хэмжээ авсан.</u> <u>Сургуулиудын ойр орчимд 3-8 хүнсний дэлгүүр ойролцоогоор байна..</u> <u>Сургуулийн ойр орчмын дэлгүүрт сургачдад архи тамхи зарахгүй байх талаар албан тоот хургуулсэн.</u> Сургуулиас 500 м гадна орчимд байрлаж байгаа дэлгүүрийн 10-20 орчим хувь нь тамхи зарж байна. Хууль хэрэгжсэнээр гарсан гол өөрчлөлт бол сургуулийн хашаанд тамхи татах асуудал огт байхгүй болж хэвшсэн, сургуулийн багш, ажилчид сургачдын хажууд тамхи татахгүй байх соёл хэвшил болж байна. Дорнговь аймаг нь 22 сургууль /16 дотуур байр/-тай нийт 12278 суралцгчидтай. Тамхини хяналтын тухай хэрэгжүүлж ажилласнаар сургууль, дотуур байрны орчинд тамхи худалдаалдаг дэлгүүр болон гар дээрээс жижиглэнгийн худалдаа хийдэг иргэн байхгүй болсон. Өсвөр үеийнхийн тамхини хамаарлын судалгаа хийж судалгааны үндсэн дээр эцэг эх, асран хамгаалагчтай нь хамт сургалтанд хамрагдсан 842 сургачдын 1,3% тамхи татдаг, 14-15 наасандаа тамхи татаж эхэлсэн 48,6%, сониуч зангаасаа болж тамхи татаж эхэлсэн нь 48,6%, найз нөхөдтэйгээ нийлэхээрээ 34,2% тамхи татаж үзсэн, 64,8% нь тамхи татдагаа гэр бүлээсээ нуудаг, 50,6% гэр бүлийн хүмүүс тамхи татдаг бол аав, ах тамхи татдаг 54,6%, 32,2% гэр бүлийнхэн тамхини хор хөнөөлийн талаар ярилцдаг, 71,6% сургууль дээр тамхини хор хөнөөлийн талаар сургалт сурталчилгaa авдаг гэсэн судалгаа гарсан. Бүх сургууль, цэцэрлэгүүд тамхини хяналтын хяналтын 9.2-т зааснаар тамхини хяналтын үйл ажиллагаатай холбогдсон зохицуулалтыг дотоод журамдаа оруулж ажилласан.. ЕБС-иуд болон дотуур байрнаас 500 метрээс дотогш тамхи худалдуулахгүй байх зохион байгуулалтын арга хэмжээг Цагдаагийн газартай хамтран хяналт тавьж ажилладаг. 	-
11	Дорнговь		

12	Өвөрхангай	Тус хуулийн заалтын хүрээнд аймгийн 30 ерөнхий боловсролын сургуулийн ойр орчим, 500 метрт үйл ажиллагаа явуулж буй худалдаа үйлчилгээний байгууллагад тамхи худалдахыг бүрэн хориглосон. Мөн аймгийн ерөнхий боловсролын сургуулийн захирагаа, сургуулийн нийгмийн ажилтны зүгээс сурагч, эцэг эхчүүдэд тамхин хор хөнөөл, ойр орчимд худалдаа үйлчилгээ эрхлэгчдэд тамхи худалдахгүй байх, түүний хуулийн зохицуулалт зэргээр зөвлөгөө мэдээлэл өгч, мэдээллийн самбарыг тогтолцоулж байна. Аймгийн цагдаагийн газар, Боловсрол, соёл, урлагийн газар, Сургуулийн захирагаа энэ чиглэлээр хамтран ажилладаг.
13	Сүхбаатар	Сүхбаатар аймгийн ЕБС-иудад нийт 184 багш, ажилчид тамхи татдаг ба үнээс 2016 оны байдлаар 141 хүн буюу 76,6%-ны тамхи татдаг байсан ба 2017 оны байдлаар 49 хүн тамхинаас гарч 26,6 % болж буурсан. Сургуулийн орчинд 500 м-ийн метр доторх байршилд хүнсний худалдаа эрхлэн сурагчадад тамхин хяналтын тухай хуулийн талаар танилцуулга хийж сургалт зохион байгуулснаар зөргөж байна. Сургуулийн ойр орчимд утаат тамхи татахыг хориглосон бөгөөд сургуулиуд дотоод журамдаа өөрчлөлт оруулан мөрдөж ажиллаж байна. Сургууль хамт олонороо тамхигүй хамт олон болох ажил өрнүүлж, Сургуулийн орчинд хүүхдийг дам тамхидалтанд өртөхөөс хамгаалах, хорт зуришилд авт ж , шохоорхон татах, бие биенээ уруу татах зэргээс сэргийлэх сургалт, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулсан. Үүний үр дундхумүүсийн тамхи татах давтамж багассан.
14	Сэлэнгэ	Тамхини хяналтын тухай хуулийн хэрэгжилтийн чиглэлээр 34 сургууль, 39 цэцэрлэгээс мэдээлэл авч нэгтгэлээ. Сургууль, цэцэрлэгийн ойролцоо 500 метрт тамхи худалдаалж байгаа аж ахуйн нэгж, дэлгүүр байхгүй байна. Сургуулийн сурагч, цэцэрлэгийн хүүхэд, эцэг эхэд архи, тамхини хор уршигийн талаар мэдээлэл сургалт сурталчилгаа хийдэг. Гэхдээ гэр бүл болон бусад орчинд томчуудын архидалт, тамхидалт их байгаа тул өсвөр наасны сурагчад архи уух, тамхи татах сонирхол төрүүлж, тодорхой нөлөөлөл үзүүлж байна. Ерөнхий боловсролын сургуулийн эмч, биологийн багш нар хамтран “Тамхини хор хөнөөл”, “Тамхи ба дам тамхидалт түүний хор нөлөө” зэрэг сургалтуудыг 5621 сургач, 455 багш, 822 эхийн төлөөлөл нийт 6898 хүнд, 18 цэцэрлэг 225 хүүхэд, 136 эцэг эхэд, нийт 7289 хүнд сургалт зохион байгуултан мэдээлэл түгээж ажилласан байна.
15	Завхан	Хуулийн хэрэгжих эхний үед маш сайн байсан бөгөөд гудамжинд ч тамхи татдаг хүн харагдахгүй болсон. Суулийн үед супдрах байдалтай байна. Сургуулийн орчинд тамхи татах үзэгдэл багассан нь сурагчдын хүмүүжил зан үйлд эерэг хандлага үсгэж байгаа юм. Сургачид ялангуяа бага наасны хүүхэд даган дуурайж суралцдаг бөгөөд улгэрлэн дагуулж буй зан үйлийн эзрэг, серег хандлагат.

		Узэл бодлыг мэдэрч, илэрхийлэх, түннд суралцах чадвартай байдаг болохоор дээрх хууль гарсан нь оновчтой зүйл болсон гэж үзэж байна. Сумын хэмжээнд сургуулийн ойр орчимд үйл ажиллагаа явуулдаг дэлгүүр ,аж ахуйн нэгжүүд, сургуулийн хүүхдүүдэд тамхи татахгүй байх талаар гэрээ байгуулж ажиллаж байна.
16	Төв	<p>Тамхини хяналтын тухай хууль хэрэгжиж эхэлсэн даруйдаа орон нутгийн засаг захирагаанаас 500 м-т тамхи худалдаалахыг хориглох залалт хэрэгжиж байсан. Тус хууль хэрэгжиж эхэлсэнээс хойш сургуулийн орчинд иргэдийн тамхидалт байхгүй болж, <u>хүүхдүүдийн тамхинд дурлах даган дуурдаж байдал багассан</u>. Одоогийн байдлаар 7 сургуулийн ойр 500 метр дотор тамхи худалдаалдаг цэг байсаар байгаа бөгөөд нууцаар худалдаалсаар байна. Энэ тал дээр хуулийн хүрээнд худалдааны байгууллагад шийдвэр гаргах түвшнийхэн хяналт тавьж хамтарч ажиллах нь зүйтэй байна.</p> <p>Тус хуль гарахаас ёмно сургуулиудын орчин, дотуур байранд 500 метрийн дотор байрладаг дэлгүүрүүд олон байсан бөгөөд тамхи худалдаалах тусгай зөвшөөрлийг бүгд эзэмшиж байсан. Хууль гарсан цагаас эхлэн тусгай зөвшөөрлийг албан ёсоор эрх бүхий байцааг цуцалсан нь одоо ч дагаж мөрдөж байна. Хуулийн хэрэгжилтэд аймгийн БСУГ, МХГ, ЦГ хамтран хяналт тавьж ажиллаж байна.</p>
17	Хөвсгөл	<p>Одоогоор тамхини хуулийг мөрдөх байдал 80-90%-тай байгаа бөгөөд зөрчил илрүүлэх багийн хяналтаар /хяналтын багт улсын байцаач, нийгмийн ажилтан, цагдаагийн хэсгийн төлөөлөл /нууцаар худалдан борлуулсан дэлгүүрийг илрүүлж зохих хариуцлагыг тооцож ажилласан.</p> <p>Тухайн хууль хэрэгжсэнээр сургуулийн <u>орчин дахь тамхи татах хэрэглээ 98%-р буурсан / галч нар галлаганыхаа өрөөнд татдаг нь илэрсэн./ бөгөөд тамхи хэрэглэдэг багш, ажилчид хуухдийн нүдэнд ил татах байдал угий болж байна.</u></p>
18	Хэнтий	<ul style="list-style-type: none"> • Сургууль, дотуур байраас 500 метрийн дотор тамхи худалдаалдаг цэг аж ахуйн нэгж байгууллага аймгийн хэмжээнд байхгүй. • Цагдаагийн тасгийн ажилтнууд, “school police”-ийн хамтарсан эргүүлээр тамхи ширхэгтэн борлуулж, насанц хүрээгүй хүүхдэд тамхи худалдсан иргэдийг илрүүлэн уг хуулийн 13.11-д зааснаар арга хэмжээ авч ажилласнаар зөрчил гарахгүй болсон. • Сургуулийн хүүхдүүдийн дунд судалгаа, тандалт хийхэд тамхи сонирхож татаж узсэн, татаж сурсан гэх байдал эрс буурсанд дун мэдээ гарч байна.
19	Нийслэл	<p>Тус хуулинд нэмэлт, өөрчлөлт орсноор ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байр болон дотуур байрнаас 500 метрийн дотор тамхи худалдаах, 21 нас хүрээгүй хүнд тамхи худалдаах, мөн сургууль, цэцэрлэгийн орчинд утаат тамхи татахыг тус хориглосноор үр дүнгээ өчүү сургууль.</p>

	<p><u>Цэцэрлэгийн орчинд тамхи худалдах нь эрс буурсан.</u></p> <p>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захиррагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.6-д “Эко сургууль”, “Ногоон цэцэрлэг” яныг хэрэгжүүлж хүүхэд зэлтэй эрүүл, аюулгүй орчин бий болгооор заасан. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хурээнд тус хуулийн хэрэгжилтийн талаар холбогдох байгууллагуудтай хамтарч судалгаа хийхээр төлөвлөөд байна.</p>
	<p>Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, БСШУСЯ</p>